

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН БАГШИЙН ОРОН ТОО,
ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ БАГЦ ЦАГААР ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монгол Коосэн” Технологийн коллеж /цаашид МКТК гэх/-ийн багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, гүйцэтгэсэн ажлын багц цагийн хэмжээ, үр дүнг тодорхойлж, урамшуулах, бүтээлч үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулахад энэ журам үйлчилнэ.
- 1.2. Журам нь Дээд боловсролын тухай хууль, Боловсролын яамны сайдын холбогдох тушаал, Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт, холбогдох бусад дүрэм, журмын хүрээнд үйлчилнэ.
- 1.3. Баталсан сургалтын төлөвлөгөө, боловсролын норм, нормативыг үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах багшийн орон тоог сургуулийн захирал тогтооно.
- 1.4. Гадаад хэл, мэдээллийн технологийн үндэс, бүтээх ухаан, лаборатори дадлага, туршилтын хичээлийг мэргэжлийн багшийн хүрэлцээ, сургуулийн цалингийн сангийн хэмжээ, материаллаг орчин, нөхцөлийг харгалзан дэд бүлгээр хичээллүүлж болно.
- 1.5. Энэ журмын 2-р зүйлд заасан ажлыг гүйцэтгэж буй МКТК-ийн багшийн багц цагийн гүйцэтгэл 70 хувиас дээш бол тухайн багшийг *үндсэн* багшид тооцно.
- 1.6. Нэг багц цагийн хэмжээ нь 35 цагтай тэнцүү байна.
- 1.7. Лекц семинарын хичээлийг нэг ангид 35-аас илүүгүй оюутантайгаар тооцож сургалтыг явуулна.

Хоёр. Багшийн гүйцэтгэх ажлын төрөл

- 2.1. Багшийн гүйцэтгэх ажил нь 3 үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

- Сургалтын ажил /А цаг/
- Эрдэм шинжилгээ, инновац /Б цаг/
- Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/

2.1.1. Сургалтын ажил /А цаг/

- Сургалтын хөтөлбөр, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн хэрэглэгдэхүүн болох үзүүлэн, тараах материал, тест бэлтгэх, улсын шалгалт авах;
- Лекц, семинар, лаборатори, дадлагын хичээл заах, удирдах, суралцагсдын мэдлэг, чадварыг үнэлэх, суралцагсдад зөвлөгөө өгөх;
- Үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн судалгааны ажил удирдах, зөвлөх, шүүмжлэх;
- Ангийн зөвлөх багшаар ажиллах;
- Сонгон суралцах хичээл, дугуйлан секц, клуб удирдах.

2.1.2. Эрдэм шинжилгээ, инновац /Б цаг/

- Судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх;
- МКТК, Монголын Технологийн коллежийн үндэсний холбоо, улс, олон улсын хэмжээний онол, практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлэх;
- Ном, сурах бичиг, гарын авлага бичих, хэвлүүлэх;
- Оюуны өмчийн эрх, патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авах, баталгаажуулах;
- Ном, сурах бичиг, гарын авлага орчуулах, редакторлах.

2.1.3. Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/

- Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажил;
- Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажил;
- Оюутны хөгжил, төлөвшилтэй холбоотой ажил;
- Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажил;
- Оюутны эрдэм шинжилгээний ажил удирдах, оюутны эрдэм шинжилгээний хурал, олимпиад, мэргэжлийн уралдаан зохион байгуулах, шүүгчээр ажиллах;
- Бусад үүрэгт ажил.

Гурав. Багшийн багц цаг төлөвлөх, гүйцэтгэлийг дүгнэх

3.1. МКТК-ийн багшийн гүйцэтгэх ажлын онцлог, шаардлагаас хамаарч дараах шатлалтай орон тоон дээр ажиллуулна. Үүнд:

- Тэнхимийн эрхлэгч
- Профессор
- Дэд профессор
- Ахлах багш
- Багш
- Дадлагажигч багш

3.2. Багшийн албан тушаалын шатлалыг 3-5 жил тутамд тогтооно.

3.3. Багшийн хичээлийн жилд гүйцэтгэх багц цагийн хэмжээ багшийн албан тушаалын зэрэглэлээс үл хамааран 24 багц цаг байна.

3.4. Багшийн заавал биелүүлэх багц цагийг албан тушаалын зэрэглэлээс хамааруулан дараах байдлаар тогтооно.

№	Албан тушаал	Гүйцэтгэх ажлын хэмжээ			
		Сургалтын ажил /А цаг/	Эрдэм шинжилгээ, инновац /Б цаг/	Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/	Нийт ноогдол багц цаг
1	Тэнхимийн эрхлэгч	13	5	6	24
2	Профессор	15	5	4	24
3	Дэд профессор	16	4	4	24
4	Ахлах багш	17	3	4	24
5	Багш	18	2	4	24
6	Дадлагажигч багш	19	1	4	24

- 3.5. Багш А, Б, В цагийн гүйцэтгэлийг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд дутуу гүйцэтгэсэн тохиолдолд нэг багц цагийн дундаж үнэлгээгээр үржүүлсэнтэй тэнцүү мөнгөн суутгал хийгдэнэ.
- 3.6. Багш А, Б, В цагийн гүйцэтгэлийг биелүүлээгүй тохиолдолд А, Б цагийн гүйцэтгэлээс нөхөн тооцож болно. Нөхөж тооцохдоо шилжүүлэх багц цагийг 0.8 коэффициентоор үржүүлнэ.
- 3.7. А, Б, В цаг тус тусдаа биелсэн тохиолдолд А цагийн илүү хөлсийг олгоно. Гэхдээ Б цагаас А-д шилжүүлэн илүү гаргахгүй ба түүнд хөлс олгохгүй.
- 3.8. А, Б, В цаг тус тусдаа биелсэн бол Б цагийн нормоос давсан багц цагт илүү цагийн хөлс олгоно. Б цагийн илүү хөлсийг олон улсын эрдэм шинжилгээний хуралд МКТК-ийн нэр дээр 1-р зохиогчоор оролцсон багшид тооцон олгоно.
- 3.9. Хичээлийн жилийн эцэст багш өөрийн гүйцэтгэсэн сургалт А цаг, эрдэм шинжилгээ инновац Б цаг, сургууль, олон нийтийн үйлчилгээ В цагийн ажлын гүйцэтгэлийг гаргах ба тэнхимийн эрхлэгч тодорхойлж, сургалтын менежер хянана.
- 3.10. Багш сургуулийн удирдлагын шийдвэрээр өөр ажилд томилогдох, гадаад дотоодод мэргэжил дээшлүүлэх, бүтээлийн болон захиргааны чөлөө авах, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсний болон амаржсаны амралттай гэх зэрэг шалтгаантай хугацаанд багшийн сургалтын А цагийн нормоос хорогдуулж тооцно. Багш хувийн шалтгаанаар чөлөө авсан тохиолдолд А цагийн хорогдуулалт хийхгүй.
- 3.11. Багц цагийн төлөвлөгөө, багц цагийн гүйцэтгэлийн хэмжээг үндэслэн багшийн цалин, амралтын тооцоо, илүү цагийн хөлсийг бодож олгоно.

3.12. Ангийн зөвлөх багш, анги, лаборатори, дадлагын газар, дугуйлан секц, клуб хариуцаж ажилласны нэмэгдэл олгоно:

3.12.1. Ангийн зөвлөх багшид анги хариуцаж ажилласны нэмэгдлийг сар бүр 1-р курсийн 1 оюутны 5000 (таван мянган) төгрөгөөр 2-оос 5 дугаар курсийн 1 оюутны 3000 (гурван мянган) төгрөгөөр тооцно. Нэмэгдлийг анги удирдсан багшийн нэмэгдэл олгох хуудсанд заасны дагуу олгоно:

- Оюутны ирц, цаг ашиглалт -10 хувь
- Оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааны оролцоо, зохион байгуулалт -30 хувь
- Ангийн сургалтын төлбөр төлөлт -20 хувь
- Товлосон хугацаанд дүн мэдээ, тайлан, гэрээ хийсэн байдал -20 хувь
- Ангийн ажлын цаг ашиглалт -20 хувиар, нийт 100 хувиар дүгнэнэ.

3.12.2. Ангийн зөвлөх багшаар ажилласан тохиолдолд цагийн тооцооны хуудсыг үндэслэн 2 хүртэлх багц цаг тооцно.

3.12.3. Анги танхим, лаборатори, дадлагын газар, клубийн өрөө хариуцаж ажилласны нэмэгдэл хөлсийг сар бүр 1 м.кв (нэг метр квадрат)-ыг 1000 (нэг мянган) төгрөгөөр тооцон олгоно. Нэмэгдлийг анги, лаборатори, дадлагын газар, дугуйлан секц, клубийн нэмэгдэл олгох хуудсанд заасны дагуу олгоно.

- Анги, лаборатори, дадлагын газар, дугуйлан секц, клубийн эмх цэгц, цэвэрлэгээ, ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа -100 хувиар дүгнэнэ.

3.12.4. Сонгон суралцах хичээл, дугуйлан секц, клуб удирдсан тохиолдолд тэнхимд 4 багц цаг, удирдсан багшид 2 багц цаг тооцно.

3.12.5. Дугуйлан секц, клуб удирдсаны нэмэгдлийг сар бүр 1 оюутны 3000 (гурван мянган) төгрөгөөр тооцно. Дугуйлан секц, клуб удирдсан багш нь сар бүр оюутны ирцийн мэдээг Оюутны албанд гаргаж өгөх, Оюутны албаны мэдээг үндэслэн нэмэгдлийг тооцно. Хичээлийн жилийн эцэст дугуйлан секц, клуб удирдсан багш, оюутнууд тайлан тавина.

Дөрөв. Багшийн ажлын гүйцэтгэлийг багц цагаар тооцох аргачлал

4.1. Сургалтын ажил /А цаг/

4.1.1. Лекц, семинар, дадлага, лабораторийн хичээлийн 35 цаг нь 1 багц цаг байна.

4.1.2. Багшийн гүйцэтгэсэн сургалтын ажлын бодит гүйцэтгэлээр багц цаг тооцно.

4.1.3. Төгсөлтийн судалгааны ажлын удирдагч багшийн багц цагийг амжилттай хамгаалсан оюутан тус бүрд дараах байдлаар тооцно.

$$Ch_p = 0.12 * C_p$$

C_p -Төгсөлтийн судалгааны ажилд харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан багц цаг

- 4.1.4. Төгсөлтийн судалгааны ажилд удирдагчаас гадна 2 хүртэл зөвлөгчийг захирлын тушаалаар томилон ажиллуулна. Зөвлөгчийн ажлын хөлсийг төгсөлтийн судалгааны ажил хамгаалсан оюутан бүрд 0.15 хүртэл багц цагаар тооцон олгоно.
- 4.1.5. Төгсөлтийн судалгааны ажлын шүүмж тус бүрд 0.1 хүртэл багц цаг тооцох бөгөөд шүүмжлэгч 5 хүртэл төгсөлтийн судалгааны ажилд шүүмж бичнэ.
- 4.1.6. Төгсөлтийн судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт, жинхэнэ хамгаалалтад бүрэн суусан, хамгийн багадаа 1 оюутны төгсөлтийн судалгааны ажлын бичвэрт шүүмж бичсэн гаднын гишүүний ажлын хөлсийг хамгаалсан оюутан тус бүрд 0.02 багц цагаар тооцож олгоно.
- 4.1.7. Төгсөлтийн комиссын нарийн бичгийн даргад оюутан бүрд 0.003 багц цаг, төгсөх оюутны ангийн зөвлөх багшид дүн тулгалт хийсэн тохиолдолд оюутан бүрд 0.02 багц цаг тус тус тооцон олгоно.
- 4.1.8. Оюутны үйлдвэрлэлийн дадлага удирдахад нэг оюутнаас дадлагын удирдагчид ноогдох багц цагийг дараах томъёогоор тооцно. 1 багц цагийн төлбөрийг 525,000 (таван зуун хорин таван мянган) төгрөгөөр тооцно.

$$Ch_d = 0.06 * C_d$$

C_d -тухайн дадлагад харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан багц цаг

- 4.1.9. Танилцах, хээрийн, геодезийн дадлага удирдсан багшид ажилласан хоногийн цалинг тооцон олгоно.
- 4.1.10. Сургалтын албанаас зөвшөөрөгдсөн клуб, секц, сонгон, дугуйланг 15-30 хүртэлх оюутантайгаар хичээллүүлэхэд үр дүн 75%-иас дээш тохиолдолд харгалзах багц цагийг тооцон олгоно.

4.2. Эрдэм шинжилгээ, инновац /Б цаг/

№	Шалгуур	Хэмжих нэгж	Ноогдох багц цаг	Тайлбар
1	Web of science IF – JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	8 кр	Тухайн албан тушаалд харгалзах Б цагийг бүтэн тооцно.
2	Web of science-д бүртгэлгүй боловч Мэргэжлийн түвшинд хянагддаг гадаад хэл дээр хэвлэгддэг олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	6 кр	
3	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	5 кр	
4	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд хураангуй хэвлүүлэх	1	3 кр	
5	Гадаадад зохион байгуулсан олон улсын хуралд poster илтгэл хэвлүүлэх, танилцуулах	1	2 кр	
6	Дотоодод зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	3 кр	
7	Улсын хэмжээний Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	2 кр	

8	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний хэвлүүлэх	1	2 кр	
9	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд илтгэлийн хураангуй хэвлүүлэх	1	1 кр	
10	Монограф буюу нэг сэдэвт зохиол	1 х.х	1 кр	
11	Гадаад хэл дээр бичигдсэн монограф	1 х.х	1.2 кр	
12	Доктор /PhD/-ын диссертаци	1 ажил	6кр	
13	Магистрын ажил	1 ажил	4 кр	
14	Сурах бичиг	1 х.х	0.5 кр	Сургуулийн хэрэгцээнд зориулан зохиосон Сурах бичиг (редакцын зөвлөлөөр хянагдсан), гарын авлага, зөвлөмж, орчуулгын бүтээл зэрэгт тооцох багц цагийг бэлэн болсон бүтээлийг үндэслэн тооцно. Олон зохиогчтой бүтээл бол нийт багц цагийг тэнцүү хувааж тооцно.
15	Гарын авлага, зөвлөмж	1 х.х	0.3 кр	
16	Орчуулгын бүтээл	1 х.х	0.5 кр	
17	Олон улсад эшлэл татагдсан бүтээл	1 эшлэл	1 кр	
18	Дотоодод эшлэл татагдсан бүтээл	1 эшлэл	0.5 кр	
19	Боловсруулж батлуулсан Олон улсын стандарт /ISO/ Боловсруулсан- Оролцсон-	1	3 кр	
		1	2 кр	
Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх				
20	Гадаадад зохион байгуулсан олон улсын хуралд Зочин илтгэл - илтгэл-	1	4 кр	Эрдэм шинжилгээний хурлын багц цагийг хурлын үндсэн илтгэгчид бүтнээр, илтгэлийн бусад оролцогчдод тэнцүү хувааж тооцно. 5-аас доошгүй улсын судлаачид оролцсон эрдэм шинжилгээний хурлыг олон улсын хурал гэж тооцно. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн, хэлэлцүүлсэн тохиолдолд 1-р зохиогч, илтгэл хэлэлцүүлсэн илтгэгчид тооцох багц цагийг бүтнээр бусад илтгэгчид тэнцүү хувааж олгоно.
		1	3 кр	
21	Дотоодод зохион байгуулсан олон улсын хуралд Зочин илтгэл-	1	2 кр	
22	Улсын болон салбарын хэмжээнд илтгэл хэлэлцүүлэх -poster илтгэл	1	3 кр	Хуралд оролцож буй байгууллагын тоо 3-аас олон бол улсын хэмжээний хурал гэж тооцно.
		1	1.5 кр	
23	Сургуулийн хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлэх	1	2 кр	
24	Оюуны өмчийн эрх, патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авах -гадаад - дотоод	1	8 кр 6 кр	
25	Сургуулийн нэр дээр Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	1	4 кр	

4.3. Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/

№	Шалгуур	Хэмжих нэгж	Ноогдох багц цаг	Тайлбар
1	Сургалт, заах арга зүй, сургалтын технологийг боловсронгуй болгох, заавар, дүрэм, бусад бичиг баримт боловсруулах	1 багц	1 кр	1 иж бүрэн сургалтын хөтөлбөр, комиссын гишүүнээр ажиллах
2	Багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх, эсвэл багшийг дагалдуулах, өөрийн хичээлд суулгах	1	0.5 кр	
3	Нээлттэй хичээл заах	1	1 кр	Үнэлгээг харгалзан үзнэ.
4	Мэргэжлийн чиглэлээр мэргэжил боловсролоо дээшлүүлэх	1 сургалт	0.5 кр	Сертификат, үнэмлэх
5	Хамт олны дунд төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах	1	1 кр	Ажлын үр дүнг харгалзан үзнэ
6	Оюутны дунд семинар, сургалт, уралдаан, тэмцээн зохион байгуулах	1	0.5 кр	
7	Оюутны үйлдвэрлэлийн дадлага хийлгэх талаар ажил олгогчтой хамтран ажиллах гэрээ байгуулах	1 байгууллага	0.3 кр	
8	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн мэдээллийн сан бий болгох	1 жилд	1 кр	
9	Оюутны нийгмийн идэвх, оролцоог дэмжсэн бүтээлч ажил	1 ажил	0.5 кр	
10	Сургуульд эко орчныг бүрдүүлэх, хамгаалахад чиглэсэн ажил	1 ажил	0.5 кр	
11	Сургуулиа олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх	1 ажил	0.5 кр	
12	Сургалтын газрыг тохижуулах, ашиглалтыг сайжруулах	1 жилд	1 кр	
13	Стандартын дагуу шинээр сургалтын газар, кабинет, лаборатори, дадлагын газар байгуулах	1	2 кр	

Тав. Багц цагаар үл хэмжигдэх үйл ажиллагаа

- 5.1. Өндөр үр ашигтай буюу ач холбогдолтой төсөл, сургалт зохион байгуулж хэрэгжүүлсэн багшид үр ашиг, ач холбогдлоос хамааруулан Удирдах зөвлөлийн шийдвэрээр сургуульд үлдэх ашгийн тодорхой хувиар урамшуулал олгож болно.
- 5.2. Сургуулийн захиргааны шийдвэрээр илүү цагаар ажилласан тохиолдолд зохих хууль, тогтоомжийн дагуу хөлсийг олгоно.

Зургаа. Гэрээт багшийн багц цагийг тооцох

- 6.1. Хичээлийн цагийн нэг багшийн ноогдолд хүрэхгүй, тухайн мэргэжлийн багшийн хүрэлцээ муу бол цагийн багш гэрээгээр /цаашид гэрээт багш гэх/ ажиллуулна.
- 6.2. Гэрээт багш нь МКТК-ийн багшид тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, багшлах дадлагатай, мэргэшсэн байна.
- 6.3. Гэрээт багшийн сургалтын ажлын нэг багц цагийн үнэлгээг тухайн багшийн эрдмийн болон мэргэжлийн зэрэг, цол, туршлага, ур чадвараас хамааруулан гэрээнд нарийвчлан тусган, хичээлийн жил тутамд захирлын тушаалаар баталгаажуулна.
- 6.4. Тус сургуулийн удирдах албан тушаалтан болон багш бус орон тоон дээр ажиллаж байгаа ажилтны сургалтын ажлын хэмжээг гэрээгээр зохицуулна. Энэ тохиолдолд жилийн нормт цаг 240-өөс хэтрэхгүй байна. Үнэлгээг энэ журмын 6.3 дахь хэсгийг үндэслэн тогтооно.
- 6.5. Үндсэн орон тооны багшийн албан тушаалаас гадна захирлын шийдвэрээр зөвлөх профессорыг гэрээгээр ажиллуулж урамшуулал олгоно. Зөвлөх профессор нь өөрийн оюуны чадавхыг өвлүүлэн үлдээх, шавь багш бэлтгэх, эрдэм шинжилгээний сэдэвт ажил удирдах, сургалт арга зүйн зөвлөгөө өгөх үүрэгтэй.